

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 05 дугаар сарын мэдээ

2023.05.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Тухайн сард дээд газраас 28 албан бичиг ирсний 8 нь хариутай, хугацаа болоогүй-2, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг суманд хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын албан байгууллага, ААН, иргэд, сурагчдын дунд бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулж байна.

ОНХС-ийн 120.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын Хог зөөврийн 10 тн-ын автомашиныг худалдан авч ажлын хэсэг хүлээн авч жолоочид хүлээлгэн өглөө.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Монвеком ХХК" ЭМТ-д 4 төрлийн шүүлтүүрээр шүүх чадалтай халуун, хүйтэн ус гаргах боломжтой ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг хийж гүйцэтгэлээ

"Сүхбаатар аймаг- хөгжилд хамтдаа" хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганд оролцсон.

УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал аймгийн засаг дарга М. Идэрбат нараар ахлуулсан ажлын хэсэг 05 дугаар сарын 26 -нд тус суманд ажиллаж иргэдтэй уулзалт хийж цаг үеийн асуудлаар мэдээлэл хийхийн зэрэгцээ Монгол улсын засгийн газраас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаархи иргэдийн саналыг сонсож ажиллаа.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг , Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 4 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч наториатоор баталгаажуулж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан , малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарийн дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Төсвийн газруудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хугацаанд нь e-balance программд шивж сумын нэгдсэн тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж, аудитын газар хүргүүлж шалгуулсан.

Гүйлгээний баримтыг сар бүр архивлан үдсэн. Шилэн дансны мэдээллийг шивж оруулсан.

2023 оны хагас жилийн малын түүвэр судалгааг Аймгийн засаг даргын захирамжийн дагуу сумын засаг даргын захирамж гарч бэлтгэл ажил хийдэж байна.

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Бүрэн дунд сургуулийн 6-12 р ангийн 312 сурагчид “Тарьсан модыг хэрхэн арчлах тухай “сэдвээр зурагт хичээлийг зааж тэдний саналыг гадна талбайд ургаж байгаа моднууд дээр тариалт хийх талаар зааж үр дүнг ярилцлаа.

БИНХ-ыг хуралдуулж Сумын засаг дарга цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, цагдаагийн тасаг, ЗДТГ-ын ХЭЗХ мэргэжилтэн нар замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэр бүлийн хүчирхийлэлийн чиглэлээр сургалт зохион байгуулж гарын авлага түгээн ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт- 450 урьдчилан сэргийлэх үзлэг – 180 иргэн хамрагдлаа. Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт – 42 иргэнээс 0-5 насны хүүхэд – 12 байна. Алсын дуудлага – 14, АНЭ-т 4 удаа өвчтөн тээвэрлэсэн байна. Ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн. Жирэмсний хяналтанд нийт 5 эх орсноос эрт хяналт- 5, АНЭ-т төрсөн- 7, Суманд төрсөн- 1, Эх хүүхдийн эргэлт – 10, Эсийн шинжилгээ – 9, Хөхний үзлэгт – 41. СЗЭ-ний кабинетаар нийт 56 үйлчлүүлэгч тусламж үйлчилгээ авсан.

Ерөнхий боловсролын сургууль: “Хүүхдийн хөгжилд эцэг эх асран хамгаалагчдын оролцоо” сургалт өдөрлөгийг 05 сарын 04-ны өдөр БЕГ-ын СХХҮ хариуцсан ахлах мэргэжилтэн, БШУГ-ын мэргэжилтэн сургуулийн удирдлага болон “Тэригүн клуб”-ын сурагчид хамтран зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд 150 гаруй эцэг эх багш, ажилчид оролцож өртөөчилсэн хэлбэрээр бага, дунд ахлах гэсэн бүлэгт хуваагдаж мэдээлэл солилцож, 1-5-р ангийн суралцагчдын үдийн хоолны үйл ажиллагаатай танилцаж багш суралцагчдын бүтээлийн үзэсгэлэнг үзэж сонирхов.

“Хүүхэд бүрийн хөгжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт өдөрлөгийг 6-12 дугаар ангийн эцэг эхчүүдийг хамруулан зохион байгууллаа. Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Сүхбаатар аймгийн яруу найрагчид зохиолчдынхоо бүтээлээс сэдэвлэсэн "Жаахан шаргын нутаг" монгол бичгийн уралдаанд: Шилдэг судлагдахууны төрөлд Б. Пүрэвдарь ахлагчтай МХБУЗ-ын судлагдахуун шалгарч, Үзгийн хичээнгүй бичгийн төрөл, Боловсролын салбарын албан хаагчдын ангилалд П.Ягаанцэцэг багшийн бэлтгэсэн бага ангийн багш нарын баг дэд байр, Таталган бичгийн төрөлд МХБУЗ-ын багш Р.Дэлгэрцогт дэд байр, Үзгийн хичээнгүй бичгийн төрөл, 2 дахь жилдээ оролцож буй анги хамт олны ангилалд Р.Дэлгэрцогт багшийн бэлтгэсэн А.Баярмаа багштай 11б анги дэд байр, Үзгийн хичээнгүй бичгийн төрөл, анхны жилдээ оролцож буй анги хамт олны ангилалд П.Ягаанцэцэг багшийн бэлтгэсэн 8б анги дэд байр тус тус эзэллээ.

05 дугаар сарын 10-ны өдөр “OPEN MIC” арга хэмжээг амжилттай зохион байгуулж багш, ажилчид, сурагчдын санал хүсэлт, чөлөөт цагийг өнгөрүүллээ. 05 сарын 12-ны өдөр I ангийн сурагчдын “Тайлант өдөрлөг” амжилттай зохиогдлоо. 05 сарын 15-наас 05 сарын 19-ны хооронд Гүйцэтгэлийн үнэлгээний баг томилогдож ЕБС-д “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” зохион байгуулагдлаа.

IX-XII ангийн сурагчдын дунд “Хөгжөөнт буухиа” тэмцээн зохион байгуулж, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор зааланд тоглох эрхийг сургуулийн зүгээс дэмжин урамшуулж ажиллалаа. “Хүүхдээрээ бахархацгаая-Хамтдаа хөгжүүлье” эцэг эх-багш-сурагчийн хамтарсан уулзалтыг 10а ангийн эцэг эхчүүдийн дунд зохион байгууллаа.

“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд ЕБС-ийн багш сурагчид монголын бүжгийн холбооны багш Энхбаатар, Болормаа нарын хамтарсан 10 хоногийн сургалтад хамрагдан заавал сурах болон шугаман бүжгийг сурлаа

Цэцэрлэг: БШУЯ болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын ажиллагааны хүрээнд МУБИС-ийн Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн ахлах багш Н.Нямдорж , Х.Өлзийтунгалаг нарын зохион явуулсан “Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг дэмжих орон нутгийн сургагч багш бэлтгэх” сургалтанд багш Б.Бибиш хамрагдаж ирсэн ба сургалтын үр дүнд “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн зохион байгуулалт чиг үүрэг” сэдвээр сургалт зохион байгууллаа.

СӨБ-д амжилттай хамрагдан төгсөлтийн үйл ажиллагаа тайлант өдөрлөгүүд 4 бүлгийн бэлтгэл ангиуд зохион байгуулагдаж байна.

2023 оныг Хүүхэд хамгааллын жил болгосонтой холбогдуулан сумын байгууллагуудаар “Нэгдүгээрт хүүхэд” аялах дэвтэр энэ сард байгууллагад ирж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулж тайланг хавсарган дараагийн байгууллагад хүлээлгэн өгсөн.

Соёл: соёл олон нийтийн 11 үйл ажиллагаа явагдаж 1268 хүн хамрагдлаа. “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд Нийтийн бүжгийн холбооны Дархан дахь салбарын бүжгийн багш Ж.Энхбаатар, Д.Болортуяа нарыг урьж нийтийн бүжгийн сургалт зохион байгууллаа. Сургалтанд 100 хүн хамрагдлаа. ЕБС-ийн 30 сурагч хамрагдлаа. Соёлын төвийн номын сан нь 5-р сард ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа.

Номын сан нь 5-р сард ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа. Байнгын уншигч 21, ирэгсэд 78 хүнд 123 ном гэрээр олгож 8 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 3 татгалзал бүртгэлээ.

Номын сангийн автоматжуулалтын Lib4U программд фондын номыг оруулах уншигчийг бүртгэх ажлыг хийж байна.

Судар эгшиглэн-2023 төсөлд оролцогчдын унших номыг фондоос татаж бага дунд ахлах анги, насанд хүрэгсэдийн ангилалаар ангилан тусгай тавиурт байрлуулан цэгцэллээ. Судар эгшиглэн төсөлд оролцогч хүүхдүүдэд номын тэмдэглэл хэрхэн хөтлөх группд байршуулах талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна. эхний хүүхдүүд унших номынхоо 50%-ийг уншиж тэмдэглэлээ оруулаад байна.

Үндэсний бичиг үсэг-Номын баярын ажлын хүрээнд зохиогдох ажлын төлөвлөгөөний дагуу үндэсний бичигээр хэвлэгдсэн ховор номын болон шинэ хүүхдийн номын үзэсгэлэн зохион байгууллаа МУСТА Х.Ган-Эрдэнийн “Үлэмж торгон аялгуу”, П.Ганболдын “Хүн Уул”, Б.Отгонбаярын “Би ийм л хүн”, МУСТА Я.Гэрэлчулууны Hit s” тоглолтуудыг хүлээн авч ард иргэдэд хүргэлээ.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд: Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Сумын засаг даргын захирамжийн дагуу “ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН”-ийг сумын хэмжээнд 25.0 сая төгрөгний төсвөөр 6000 суулгац суулгах мөн 560 м2 хашааг шинээр суурилуулах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр халамжийн газраас “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн халамж авдаг хөдөлмөрийн чадвартай 20 иргэнийг ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих арчлах ажилд 20 иргэнийг ажиллуулж байна.

Хог хаягдлын чиглэлээр: Нэгдсэн хогийн цэгт ил задгай хог асгах, төвлөрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр 360 градус эргэдэг камерыг сууриллуулж хяналт тавьж ажиллаж байна.

ОНХС-ийн 120.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын хог зөөврийн автомашиныг худалдан авч ажлын хэсэг хүлээн авч жолоочид хүлээлгэн өгч сумын төвийн айл өрх, эзэнгүй хог хаягдал болон багуудын хорогдсон малын сэг зэмийг тээвэрлэн хогийн цэгт төвлөрүүлэн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Бэлчээр хамгаалах ажлын хүрээнд “Шим” ХХК-тай гэрээ байгуулж, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч үлийн цагаан оготно устгах бактерийн бэлдмэл малын тоо толгойн албан татварын орлогоос 2 тн , улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,75 тн бэлдмэл нийлүүлсэн, Нийт 3,75 тн оготно устгах микробиологийн бэлдмэлийг 6 багт хуваарилж, малчдын оролцоотойгоор оготно устгалын ажлыг зохион байгууллаа.

Өвөлжилт, хаваржилт хүндэрч сумын хэмжээнд нийт хорогдсон мал нь оны эхний нийт малын 8.2 % буюу 46441 толгой мал хорогдоод байна. Үүнд: тэмээ -2, адуу – 1939, үхэр -2551, хонь – 22402, ямаа – 19547

05 дугаар сарын 19 - 20 –ны өдрийн цаг агаарын гамшигт үзэгдлийн үед 3407 толгой мал хорогдсон. Үүнд: тэмээ -1, адуу 87, үхэр 87, хонь 1434, ямаа 1798

Гамшгийн үед хорогдсон малын тоог өрх тус бүрээр гаргаж судалгааг ХХААГазарт хүргүүлсэн.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн